



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 413

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Геронтологийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 230,533,297.00 (хоёр зуун гучин сая таван зуун гучин гурван мянга хоёр зуун ерэн долоон) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамц, Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Хишигжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн  
4/3 дугаар тогтоолын хавсралт



ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуриглагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Компьютер	2007.01.01	2	878 200	1 756 400	1 756 400	-
2	Компьютер	2007.01.01	1	1 408 400	1 408 400	1 408 400	-
3	Кодоскоп	1999.01.01	1	8 683 200	8 683 200	8 683 200	-
4	ЭХО аппарат	1999.01.01	1	203 512 500	203 512 500	203 512 500	-
5	Нойрсуулах цахилгаан аппарат	1999.01.01	1	10 311 300	10 311 300	10 311 300	-
6	Дижитал зургийн аппарат	2007.01.01	1	316 100	316 100	316 100	-
7	Булчингийн техник аппарат	1999.01.01	1	144 700	144 700	144 700	-
8	Эмнэлгийн хөшиг	2009.01.01	1	120 000	120 000	120 000	-
9	Компьютер	2011.11.04	1	682 000	682 000	682 000	-
10	Компьютер	2012.12.14	2	549 900	1 099 800	1 099 800	-
11	Дэлгэц LCD	2012.12.14	2	129 900	259 800	259 800	-
12	Компьютер	2008.01.01	1	495 250	495 250	495 250	-
13	Телевизор	2001.01.01	1	259 600	259 600	259 600	-
14	Тог баригч	2001.01.01	1	130 200	130 200	130 200	-
15	Дарга сандал	2007.01.01	1	182 500	182 500	182 500	-
16	Компьютерийн шар ширээ	1993.01.01	1	18 100	18 100	18 100	-
17	Хөгжим	2008.01.01	1	184 900	184 900	184 900	-
18	Цагаан шкаф	1982.01.01	1	1 300	1 300	1 300	-
19	Самбар	2010.05.01	1	39 000	39 000	39 000	-



20	Сандал хар төмөр	2010.01.01	2	9 216	18 432	18 432	-
21	Эвхдэг хар сандал	1999.01.01	5	7 330	36 650	36 650	-
22	Дижитал зургийн аппарат	2009.01.01	1	474 309	474 309	474 309	-
23	DVD тоглуулагч	2008.01.01	1	74 900	74 900	74 900	-
24	Хар сандал	2008.01.01	2	18 000	36 000	36 000	-
25	Эргэдэг сандал	1999.01.01	4	71 989	287 956	287 956	-
	<b>НИЙТ ДҮН</b>	-	<b>37</b>	<b>228,702,794.00</b> (хоёр зуун хорин найман сая долоон зуун хоёр мянга долоон зуун ерэн дөрвөн)	<b>230,533,297.00</b> (хоёр зуун гучин сая таван зуун гучин гурван мянга хоёр зуун ерэн долоон)	<b>230,533,297.00</b> (хоёр зуун гучин сая таван зуун гучин гурван мянга хоёр зуун ерэн долоон)	-